

= 2024 оны Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

Мон-Гео ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 27-ны 10 цаг 25 минутад өөрийн байранд эхлүүлэв.

Оролцсон нь:

Н.Соёмбо-	ТУЗ-ийн дарга
Х.Анар	ТУЗ-ийн гишүүн
М.Алтанцэцэг-	ТУЗ-ийн гишүүн
Н.Тулга-	ТУЗ-ийн игишүүн
Ц.Алтансүх-	ТУЗ-ийн гишүүн
М.Адилбиш-	ТУЗ-ийн гишүүн
Б.Нямдэлгэр –	ТУЗ-ийн гишүүн
Э.Норовринчин-	ТУЗ-ийн гишүүн
А.Ганцэцэг-	Ня-бо
Н.Бат-Өлзий-	Компанийн ажилтан
Г.Даваажаргал-	Компанийн ажилтан
Б.Түмэнжаргал-	Компанийн ажилтан

Хувьцаа Эзэмшигчдийн хурлын дарга Н.Соёмбо: 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц 79,6 хувь байгааг танилцуулж, саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд ирсэн байна.

Хурлын ирцийг хангалттай гэж үзээд хурлаа эхлүүлье гэснээр хурлын ажиллагаа эхлэв. Хурлын нарийн бичгийн даргад Н.Тулгын нэрийг дэвшүүлж 100 хувийн саналаар дэмжив. 2024 оны ээлжит хурлын дэгийг Х.Анар, хурлаар хэлэлцэх асуудлуудыг М.Алтанцэцэг нар тус тус танилцуулав.

Хэлэлцсэн нь:

Х.Анар өнөөдрийн өдөр хуралдаж байгаа хурал маань 10 цаг 20 минутад эхэлж 16 цагийн үед өндөрлөх болно гээд хурлын дэгийг танилцууллаа.

М.Алтанцэцэг: Хурлаар

Компанийн үйл ажиллагааг хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн хурлын шийдвэрүүд, холбогдох байгууллагуудын дүрэм журмын хүрээнд явууллаа. Манай компани өөрийн эзэмшлийн ҮХЭХ болох 2 давхар 2013 м.кв байрын өрөөнүүдийг 97,5 хувь түрээслэн үйл ажиллагаагаа явуулж байна. Компани үндсэн үйл ажиллагааны чиглэлээрээ үйл ажиллагаагаа явуулах хүсэлттэй байгаагаа холбогдох, удирдах дээд байгууллагуудад нь мэдэгдэж ажилласан боловч дорвитой шийдэл алга байгаа юм.

Шийдвэр ирвэл компани шаардагдах төсөв, төлөвлөгөөг тооцон гаргаж үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллахад асуудал гарахгүй хэмээн танилцууллаа.

Компанийн тогтвортой үйл ажиллагааг хангах, санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх удирдлагад зөвшөөрөх эс зөвшөөрөх асуудлыг ярилцан шийдвэрлэнэ гэж ТУЗ-ийн дарга Н.Соёмбо ярилаа.

Тэрээр компанийн ХУД-ийн нутаг дэвсгэрт байрлалтай 8.08 га газрын ашиглалтыг гүйцэтгэх удирдлагад даалгах нь зүйтэй гэв.

Хараат бус аудиторын тайлангаар “Шинэ Их Тэр Бум Аудит”ХХК нь “Мон-Гео”ХК-ийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэсэн.

Эдгээр тайлангууд бүхий л материаллаг зүйлсийн хувьд санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэсэн гэж ня-бо А.Ганцэцэг аудиторын дүгнэлтийг танилцуулав.

Санал шүүмжлэл:

Н.Соёмбо: Хэлэлцэх асуудлууд, холбогдох тайлангууд болон дүгнэлтүүдтэй танилцаж сонслоо. Эхний ээлжинд татварын өрийг барагдуулах тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй.

Энэ онд хэрэгжүүлж эхлэх бизнес төлөвлөгөөг яаравчлан боловсруулж, хэрэгжүүлэх ажилдаа хугацаа алдахгүй шуурхайлан орох шаардлагатай байна.

Гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх асуудлыг дараагийн ээлжит хурлаар ярилцах саналтай байна. Бизнес төлөвлөгөөг шат дараатай хэрэгжүүлж эхлэх учраас энэ багаараа ажиллах нь зөв болов уу гэж үзэж байна.

Компанийн ТУЗ-ийн гишүүн Т.Батжаргал нас барсан тул нөхөн сонгох хэрэгтэй. ТУЗ-ийн гишүүнд Батбаяр овогтой Доржмягмарын нэрийг дэвшүүлж байна.

Б.Доржмягмар нь 1987 оны 1 дүгээр сарын 6 нд Улаанбаатар хотод төрсөн. ЭМШУИСургуулийн НЭМСургуулийг төгссөн. Эрүүл Мэндийн эдийн засагч мэргэжилтэй. Эхнэр 4 хүүхэдтэй.

Одоогоор Төмөр Замын эмнэлэгийн даргын албыг хашиж байгаа ийм хүн байна гэж мэдээлэв.

Нэмж хэлэхэд тухайн жилдээ ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүдэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. ХУД-ийн компанийн эзэмшлийн газар дээр тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг гүйцэтгэх удирдлагад өгөх нь зүйтэй гэв.

Мөн аудитын байгууллагын санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллах хэрэгтэй байгаа нь харагдлаа. Үүн дээр анхаараарай гэж сануулав.

Ц.Алтансүх: Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, хурлаар хэлэлцэх асуудлуудтай танилцаж мэдлээ.

Ер нь ТУЗ-ийн даргын ярьсанчлан бизнес төлөвлөгөөгөө сайн тооцоо судалгаатай боловсруулж баталгаажуулах нь зүйтэй. Бизнес төлөвлөгөөгөө батлагдсан үйл ажиллагааныхаа чиглэлээ барин боловсруулах, хэрэгжүүлэх шаардлагатай.

МУ-ын Улсын бүртгэлд бүртгүүлсэн мөн өөрийн компанийн дүрмэнд заасан үйл ажиллагааны чиглэлээ баримтлан эдийн засаг, санхүүгийн чадамжид нөлөөлөх, ашиг тусаа өгөх ажлуудыг хийж гүйцэтгэх нь маш чухал санагдана.

Геологи хайгуул, кадастрын зураглал, барилгын үйл ажиллагаа, ХАА, газар тариалан гэх мэт ямар ч салбарт үйл ажиллагаа зохион байгуулсан болохоор үйл ажиллагааны давуу талтай компани.

Тиймээс аль ч салбарт үр өгөөжөө өгөхөөр төсөл, бизнес төлөвлөгөөтэй үйл ажиллагаа хэрэгжүүлж ажиллах бүрэн боломжтой харагдаж, ойлгогдож байна.

Дандаа алдагдал ярьж хүлэгдсэн мэт байдлаа сольж хамтран ажиллъя. Шинэчлэн боловсруулсан бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх учраас гүйцэтгэх захирлыг өөрчлөх шаардлагагүй гэж үзэж байна.

ХУД-ийн 12-р хорооны нутагт байх компанийн эзэмшлийн газрын зарим хэсгийг түрээслэх, зарим хэсэгт нь малын тэжээл тарих боломжтой гэсэн санал дэвшүүлж байна.

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Б.Доржмягмарыг дэмжиж байна. Хурлаас гарах шийдвэрүүдийг хүндэтгэн хүлээн авч, хэрэгжүүлэх ажиллагаанд нь оролцоно гэв.

Б.Нямдэлгэр: Тайлангуудтай танилцлаа. Хугацаа алдахгүйгээр бизнес төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулж, шат дараатай хэрэгжүүлэх үйл явцдаа шуурхайлан орох нь зүйтэй.

Сайн ажиллаж чадвал бид санхүүгийн хувьд бүрэн эерэг үр дүнтэй, чадамжтай болж чадна гэж харагдаж байна. Хамтран ажиллаж, хурлаас гарах шийдвэрүүдийг хүндэтгэн хүлээн авна.

Н.Тулга: 2024 оны жилийн тайлангуудыг сонсож танилцлаа. Хуримтлагдсан татварын өрийг төлж барагдуулах зайлшгүй шаардлагатай.

Нарийн тооцоололтойгоор компанийн нөөц бололцоон дээр тулгуурлан үйл ажиллагаагаа зөв гольдролд нь оруулахын тулд бүгд хамтран санаа, оноо, тооцоо, судалгаагаа нэгтгэн ажиллах хэрэгтэй болов уу гэж санагдаж байна. Нэмж хэлэхэд компанийн жижиг хувьцааг татан төвлөрүүлэх талдээр ч анхааран ажиллах нь ирээдүйд хэрэгтэй байх болно гэв. Хурлаас гарах шийдвэрүүдийг хүндэтгэн хүлээн авч, хамтран ажиллахад боломжгүй зүйл байхгүй.

М.Алтанцэцэг: Энэ оны ээлжит хурлаар хэлэлцэгдэж байгаа асуудлууд дээр саналаа хэлье. Бизнес төлөвлөгөөг тооцоо судалгаатайгаар шинэчлэн боловсруулах хэрэгтэй байна. Бизнес төлөвлөгөө нь хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөгүй байхаар боловсруулан, хэрэгжүүлэх тал дээр голчлон анхаарч ажиллах хэрэгтэй.

Компанийн жижиг хувьцааг төвлөрүүлэх тал дээр ажиллах нь зүйтэй. Мөн дан ганц геологийн судалгаа, зураглал, сонгон шалгаруулалт гэхээсээ илүүтэй аль хэрэглээ, хэрэгцээ их байгаа салбарт төсөл төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөгөө хэрэгжүүлж ажиллах нь хамгийн оновчтой алхам болно.

Зөв хэрэглээ, хэрэгцээтэй салбарт зөв ажиллаж чадвал санхүүгийн чадамж сайжирч, санхүүгийн хувьд алдагдлаас ч гарах боломж бүрдэнэ. Хүн бүр дор бүрнээ санаа, оноотой судалгаатай байж хамтран ажиллах нь нэн чухал байна.

Н.Соёмбо: Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, аудитын байгууллагын дүгнэлтээс үзэхэд компанийн эдийн засгийн чадавхи, санхүүгийн чадамжийг дээшлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, өргөн цар хүрээтэй ажлыг өрнүүлж үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдэд тулгуурлан үйл ажиллагаагаа чиглүүлэн тодорхой үр дүнтэй, дэс дараатай ажлуудыг төлөвлөн зохион байгуулж ажиллах нь эн тэргүүнд тавигдах зорилго болоод байгаа бөгөөд нэн шаардлагатай байна гэж дүгнэж байна.

Түүнчлэн компанийн тархсан байгаа жижиг хувьцааг татан төвлөрүүлэх нь зүйтэй. Хувьцаат компанийн давуу байдлыг ашиглан нээлттэй хувьцаа гаргаж хөрөнгө босгох арга замыг хайн судалж үзэх шаардлагатай байна.

Үүнд тохирсон урт хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулан ажиллах, сонгон шалгаруулалтад оролцон геологи, уул уурхайн холбогдолтой ажлыг эхлүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах, олох, тэдэнтэй хамтран үндсэн болон бусад чиглэлээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Мөн санхүүгийн тайлангийн хувьд аудитын байгууллагын дүгнэлтээр тэдний өгсөн заавар зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж хэрэгжүүлэн ажиллахыг гүйцэтгэх удирдлага, ня-бо нарт үүрэг болгож байна.

Х.Анар: Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангуудыг сонсож танилцлаа. Бид тайлант хугацаанд байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэл дээр шаардлагатай арга хэмжээ авч ажиллахаа илэрхийлдэг боловч холбогдох дээд байгууллагууд нь компанийн түршлага, хийж гүйцэтгэсэн ажлуудын тайлангуудад төдийлөн ач холбогдол өгч хамтарч ажиллахгүй байгаа нь харамсалтай. Хэдий тийм боловч бид үйл ажиллагааныхаа чиглэлийг Улсын бүртгэл, компанийн дүрмээрээ баталгаажуулсан чиглэлээр өөрчилж бизнес төлөвлөгөөгөө боловсруулан хэрэгжүүлж, өөр салбарт хүч үзэн үйл ажиллагааныхаа цар хүрээгээ тэлэх, бусад боломжуудыг нэмэгдүүлэх боломж нээлттэй харагдаж байгаа нь маш чухал.

Компанийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд та бүхэн шинэчлэн боловсруулах бизнес төлөвлөгөөнд ач холбогдол өгөн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэн өөрчлөх, санхүү эдийн засгийн чадамжийг дээшлүүлж, орлогын хэмжээг нэмэгдүүлж алдагдалгүй ашигтай ажиллах тал дээр онцгой анхаарч компанийн үйл ажиллагаанд хамтран идэвхитэй оролцож ажиллах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

Хурлаас гарах шийдвэрүүдийг хүлээн авч хэрэгжүүлэн ажиллах тал дээр анхаарч өөрийн хувь нэмрээ оруулна. Шинээр сонгогдох ТУЗ*-ийн гишүүнийг дэижиж байна.

М.Адилбиш: Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн чадамж, хараат бус аудитын байгууллагын дүгнэлттэй танилцаж сонслоо.

Бизнес төлөвлөгөөгөө сайтар нягтлан боловсруулж, хэрэгжүүлэх ажиллагаандаа гойд анхаарч зөв ажиллагаа явуулах нь зүйтэй болов уу.

Мөн үр дүнг нь сайн анхаарч харах хэрэгтэй. Шинээр сонгогдох ТУЗ-ийн гишүүнийг дэмжиж байна.

Гүйцэтгэх удирдлагыг солилгүйгээр бизнес төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх нь зөв байхаа. Хурлаас гарах шийдвэрийг хүндэтгэн хүлээн авч, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажиллагаанд идэвхитэй ороцоно.

А.Ганцэцэг: Тус компанийн 2024 оны санхүүгийн чадамжийн хувьд ашгийн түвшин маш бага, өр төлбөрийн хувьд татварын өглөгүүдтэй гарлаа. Энэ нь компанийн санхүүгийн үзүүлэлт ямархуу түвшинд байна, цаашлаад эхний ээлжинд юун дээр түлхүү анхаарч ажиллах, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх, хэрэгцээ хэрэглээг сайн судалж, судалгаан дээр үндэслэсэн бизнес төлөвлөгөөг даруйхан боловсруулан баталж нэн яаралтай хэрэгжүүлэх, санхүү эдийн засгийн байдалд анхаарал хандуулан ажиллах шаардлагатай байна гэдгийг бид бүхэнд илтгэж, сануулж байна.

Хурлаас гарах шийдвэрийг хүлээж авна. Аудитын байгууллагын зөвлөмж сануулгыг ажил дээрээ хэрэгжүүлэн ажиллах болно.

Шинээр сонгогдох ТУЗ-ийн гишүүнийг дэмжижи байна. Бизнес төлөвлөгөөг боловсруулах, үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх үйл явц, шат дараатай хэрэгжигдэх болж буй энэ нөхцөлд гүйцэтгэх захирлыг өөрчлөх шаардлагагүй гэж үзэж байна гэснээр санал шүүмжлэлийг тасаллаа.

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хүлээн зөвшөөрөхөөр,
2. Жилийн санхүүгийн тайланг зөвшөөрөхөөр,
3. 2024 оны жилийн санхүүгийн тайланд өгсөн “Шинэ Их Тэр бум ХХК”-ийн аудитын дүгнэлтийг зөвшөөрч холбогдох арга хэмжээг авч ажиллахаар,
4. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдах сонгон шалгаруулалтад нөөц бололцоогоо дайчлан оролцож, шаардагдах төсөв төлөвлөгөөг тооцож ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэхээр,
5. ТУЗ-ийн гишүүнээр Б.Доржмягмарыг сонгохоор,
6. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, шинээр ажлын байр бий болгох, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний гэрээ хэлцэл хийх, зээл авахыг Гүйцэтгэх захиралд зөвшөөрөхөөр,
7. Тус компанийн эзэмшлийн ХУД-ийн нутагт байрлал бүхий 8,08 га газрыг үйлдвэрлэлийн болон бусад зорилгоор ашиглах, бусдад түрээслэх, төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад даалгахаар,

8. Компанийн санхүү, эдийн засгийн чадамжийг сайжруулах, өргөжүүлэх зорилготойгоор салбар харгалзахгүйгээр бизнес төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-ийн хурлаар баталгаажуулж хяналттай, хугацаатай, шат дараалан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар,

9. Гүйцэтгэх захирлыг улираан ажиллуулахаар тус тус шийдвэрлэлээ.

Тэмдэглэл хөтөлсөн,   /М.Алтанцэцэг/